



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ТӨРИЙН БАНК ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БАТСАЙХАН ТАНАА

2013. 04. 08 №04/148 ЧАГДААГДААГ СТАЖЧИГ

Г Зөрчил арилгах тухай

Төрийн банк ХХК-ийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Банкны гүйцэтгэх захирлын 2012 оны Н/01,02,07,08,09,17 тушаалаар тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 гишүүнд орон сууцны дэмжлэгт зориулан 540.0 сая төгрөг, Н/14 тушаалаар гүйцэтгэх захирлын сургалтын төлбөрт 20,500 ам доллар, Н/11 тушаалаар ТҮЗ-ийн нарийн бичгийн даргын эмчилгээний зардалд 10.0 сая төгрөг олгосон нь ТҮЗ-ийн тогтоол, хувь нийлүүлэгчийн шийдвэрлгүй, дэмжих, нотлох баримт хангалтгүй байна.

2. ТҮЗ-ийн 5 гишүүн үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн байхад банкны тусгай нөхцөлт хөнгөлөлттэй зээлийг энгийн нөхцөлт зээлд шилжүүлээгүй, гэрээг шинэчлэх арга хэмжээ аваагүй байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллахыг Төрийн банк ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Батсайхан, Санхүүгийн газрын захирал Ж.Болормаа нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 05 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ч.БОЛД

Ж.ЦЭНГЭЛМАА



070128